

		Зээл, зээлийн батлан даалт	3,659,499,540	2,927,368,350	80.0
		Бараа, үйлчилгээ	3,175,618,500	1,257,137,307	39.6
		Үйл ажиллагааны зардал	597,915,000	463,803,597	77.5
		Сургалт	929,199,870	81,235,845	8.7
		Нийт	14,590,543,500	9,923,809,149	68.01
	Хөтөлбөрийн зорилт :	Биелэлт			
7	Бүрэлдэхүүн хэсэг-1 Бэлчээрийн удирдлага ба уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадавх сайжирсан байна.	<ul style="list-style-type: none"> - 112 Бэлчээр ашиглах малчдын бүлэг /БАМБ/ сумын Засаг даргатай “Бэлчээр ашиглах гэрээ” байгуулсан. - 73 бүлгийн хил зааг, бэлчээрийн төлөвлөгөө Газрын харилцаа геодези зураг зүйн газрын ЛМ системд орсон. - 10 сумын 78 бүлгийн бэлчээр ашиглалтын 3 жилийн төлөвлөгөө нь сумын иргэдийн нийтийн хурлаар баталгаажиж, сумын төлөвлөгөөнд туссан. - 141 БАМБ-ийн нийт 68,387,218 төгрөгийн дэмжлэг үзүүлэв. - Бүлгийн дундын сан бүрдүүлэх зорилгоор 6 аймгийн хэмжээнд 9 ТББ байгуулагдав. - 5 удаагийн сургалт зохион байгуулж нийт 545 хүнийг хамруулсан. - Бэлчээрт улирлын сэлгээ хийх арга зүйн төлөвлөгөө боловсруулах суурь судалгааны ажлыг хийв. - 148 инженерийн хийцтэй худгийг гаргаснаар 1585 малчин өрхийн 875.0 мянган толгой мал усаар хангагдаж байна. - 86 суурин угаалгын банн барьж 2.4 мянга гаруй өрхийн 1.4 сая толгой малыг угааснаар мал сүргийг паразит өвчнөөс урьдчилан сэргийлэв. - Өвс тэжээлийн агуулах, саравч засварлах ажлыг 4 аймгийн 10 суманд, шинээр барих ажлыг 4 аймгийн 11 суманд хэрэгжүүлсэн. - 6 аймгийн 9 сумд малчдын сургалт, мэдээллийн танхимыг тохижуулахад шаардлагатай тоног төхөөрөмжийг худалдан авсан бөгөөд үүний 70 хувийг төслөөс, 30 хувийг тухайн орон нутгаас санхүүжүүлсэн болно. <p style="text-align: right;">ХШҮ-93.8%</p>			
	Бүрэлдэхүүн хэсэг-2 Үйлдвэрлэл, боловсруулалтын явцад нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн зах зээлд нэвтрэх боломж сайжирсан байна.	<ul style="list-style-type: none"> - Бичил, жижиг бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр батлан даалт бүхий зээл олгохоор ХААН банктай гэрээ байгуулсанаар жилийн 13 хувийн хүүтэй зээлийг 1500 орчим иргэнд 10 тэрбум, 100 гаруй аж ахуйн нэгжид 7 тэрбум төгрөгийн зээл олгох боломжтой болсон. - 6 аймгийн 23 суманд орон нутгийн хувь хандивыг оролцуулаад борлуулалтын цэг, ажлын байрыг шинээр барих болон засварлахад 1.3 тэрбум төгрөгийг хөрөнгө оруулалт хийсэн. Үүний үр дүнд 120 орчим иргэн ажлын байраар хангагдахаас гадна 100 гаруй иргэн, аж ахуйн нэгж бараа бүтээгдэхүүнээ иргэдэд ойрхон, тав тухтай орчинд борлуулах боломжтой болсон. - Тогтвортой үйл ажиллагаа эрхэлж буй бүлгүүдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнүүдэд бар код авах эрэлт хэрэгцээг судалж 4 иргэн, аж ахуйн нэгжийн 20 төрлийн 150 бүтээгдэхүүнд бар код авахад нь дэмжлэг үзүүлж ажилласны дүнд тэдгээрийн бүтээгдэхүүний борлуулалт нэмэгдэх нөхцөл бүрдлээ. - 6 удаагийн сургалт зохион байгуулж нийт 405 хүн хамрагдсан. 			

		ХШҮ-89.0%			
8	<p>ДҮГНЭЛТ (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)</p>	<p>2020 онд төслийн 2 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд нийт 65 арга хэмжээ төлөвлөж ажилласан. Малчдыг чадавхижуулах сургалт, туршлага судлах, баримтат кино хийх, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах зэрэг нийт 18 арга хэмжээ Ковид-19 цар тахлаас шалтгаалж хэрэгжилтгүй буюу зохион байгуулагдаагүй. Эдгээр 18 арга хэмжээ нь нийт арга хэмжээний 27.7%-ийг эзлэж байна. Хяналт-шинжилгээ үнэлгээний дүнд төслийн 2020 оны хэрэгжилт 91.4 хувьтай үнэлэгдэв.</p> <ol style="list-style-type: none"> 1. Бэлчээр ашиглалтын 3 жилийн төлөвлөгөөг сумын иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулах, LM системд оруулах, сумын засаг даргатай бэлчээр ашиглах гэрээ байгуулах, суурь судалгааны ажлыг хэрэгжүүлж ажилласан нь бэлчээрийн менежментийг сайжруулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээ болсон төдийгүй орон нутгийн түвшинд бэлчээрийг зүй зохистой ашиглах, хамгаалах 144 малчны бүлэг байгуулагдсан байна. 2. Төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, худалдан авалтын арга хэмжээг орон нутагтай хамтран зохион байгуулснаар орон нутгийн хувь оролцоог нэмэгдүүлсэн ажил болсон. 3. 12000 гаруй малчин өрх төслийн үр дүнгээс үр шим хүртэж байна. 4. Ковид-19 цар тахлаас шалтгаалж сургалтын үйл ажиллагаа төлөвлөгөөний дагуу хийгдэж чадаагүй, зээлийн үйл ажиллагаа удаашралтай явагдсан. <p>ЗӨВЛӨМЖ</p> <ol style="list-style-type: none"> 1. Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам”-д нийцүүлэн төслийн зорилт тус бүрээр шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшинг дахин тодорхойлж, Сангийн сайдын 2021 оны 1 дүгээр сарын 11-ний өдрийн 4 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийг ашиглах, эдгээр хөрөнгөөр санхүүжих төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, зохион байгуулах, санхүүжүүлэх, хяналт тавих, үнэлэх журам”-ын 7.10.8.3-д заасны дагуу Удирдах хороогоор хэлэлцүүлэх арга хэмжээ авах. 2. Ковид-19 цар тахлаас шалтгаалж хойшилсон сургалт, туршлага судлах, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах зэрэг арга хэмжээг 2021 оны төлөвлөгөөнд тусгаж ажиллах 3. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ бүрээр үр дүнг тодорхой тайлагнахад анхаарах 			
9	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ	- Төсөл хэрэгжүүлэгч, оролцогч талууд уялдаа холбоотой нягт хамтарч ажилласан байна.			
10	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт	Жилийн хэрэгжилт	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2
	Тухайн жилийн гүйцэтгэлийн үнэлгээ	91.4%	2	93.8%	89.0%
11	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ	Нэгдсэн үнэлгээ			

	(ЗГХЭГ-ын үнэлгээ)	
--	--------------------	--

2020 ОНЫ ЖИЛИЙН АЖЛЫН ТӨСӨВ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

№	Төлөвлөгөөнд тусгагдсан ажил	Арга хэмжээний тоо	Үнэлгээ, %				Ковид-19 шалтгаалж хойшилсон
			100	70	30	0	
1. Бэлчээрийн менежмент ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь							
1	Бэлчээр ашиглалтын малчдын бүлгүүдийг бэхжүүлэх, туршлага судлуулах үйл ажиллагаа	8	2	2			4
2	Малчдын бүлгийн сургалт	6	4				2
3	Малчдын бүлгийн дэмжлэг, хөрөнгө оруулалт	3	3				
4	Сумын түвшний дэмжлэг, хөрөнгө оруулалт	13	9	1	1		2
5	ТББ, сумдын ажилтнуудын зардал	4	4				
Дундаж 93.8%		34	22	3	1		8
2. Зах зээлийн хөгжил бүрэлдэхүүн хэсэг							
1	Бичил, жижиг бизнес эрхлэгчдийн дэмжлэг / Бүлэг, хоршоо/	11	7				4
2	Аж ахуйн нэгж хоршооны дэмжлэг (4P бизнес төлөвлөгөөнд үндэслэсэн хөрөнгө оруулалт)	8	4			2	2
3	Хөдөө аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хоршоо, дунд үйлдвэрийн дэмжлэг	10	6	1			3
4	Зээлийн батлан даалтын дэд нэгж	2	1				1
Дундаж 89.0%		31	18	1		2	10

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

ХААХОУС	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан
ЗЗБУХТ	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл
НС	Нэмэлт санхүүжлт
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
ЗБДН	Зээлийн батлан даалтын сангийн Дэд нэгж
ХХААХЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
СЯ	Сангийн яам
ТУХ	Төслийн удирдах Хороо
ТХН	Төсөл хэрэгжүүлэх нэгж
БУУАӨДЗ	Бэлчээрийн удирдлага ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь
ЗЗХ	Зах зээлийн хөгжил
ЗБДТХ	Зээлийн батлан даалтын сангийн Техникийн хороо
МБАНХ	Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо
МҮҮХХ	Монголын үйлдвэрлэл үйлчилгээний хоршоодын холбоо
ЖАТТ	Жилийн ажлын төсөв, төлөвлөгөө
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЖДҮХГ	Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх газар

ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА

Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн (ХААХОУС) Захирлуудын Зөвлөлөөс 2011 оны 5 дугаар сард Монгол улсын Засгийн газартай хамтран “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” (ЗЗБУХ) төслийг хэрэгжүүлэхээр 7.25 сая Зээлжих Тусгай Эрхтэй тэнцэх (10 сая ам.доллар) нэн хөнгөлөлттэй зээлийг ХААХОУС-аас, 1.5 сая ам.долларын буцалтгүй тусламжийг Даян дэлхийн байгаль орчны сангаас санхүүжүүлэхээр баталсан. Төслийн эхний шат 2012-2017 онд 5 жилийн хугацаатай Архангай, Булган, Хөвсгөл, Хэнтий, Говь-Алтай аймгуудад хэрэгжсэн.

2016 онд 6.48 сая Зээлжих Тусгай Эрхтэй тэнцэх (9.06сая ам доллар) Нэмэлт Санхүүжилтийг холимог нөхцөлтэйгээр олгохоор ХААХОУС баталсан бөгөөд 2018 оны 3 дугаар сарын 30-ны өдөр хүчин төгөлдөр болсон.

Монгол Улсын Их Хурлаас 2011 оны 07 сарын 8-ны өдөр төслийн Санхүүжилтын гэрээг соёрхон баталж, 2017 оны бдугаар сарын 9-нд Нэмэлт өөрчлөлтийг баталгаажуулсан болно.

ЗЗБУХТ-ийн Нэмэлт санхүүжилт 2018 оны 5 сараас 2022 оны 9-р сарын 30-ны хооронд хэрэгжих бөгөөд зээл хаагдах хугацаа 2023 оны 3-р сарын 31 болно. Нэмэлт санхүүжилт нь Архангай, Өвөрхангай, Дундговь, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудад үйл ажиллагаа явуулж байна.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО НЬ: Хөдөөгийн иргэдийг орлогыг нэмэгдүүлж, амьжиргаагаа тогтвортой дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Төсөл нь доорх бүрэлдэхүүн хэсгүүдтэй. Үүнд:

- 1.Зах зээлийн хөгжил
- 2.Бэлчээрийн менежмент ба уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь
- 3.Төслийн менежмент ба бодлогын дэмжлэг

Газар зүйн хамрах хүрээ: 6 аймгийн 24 суманд хэрэгжиж байна. Үүнд:

- Архангай аймаг: Эрдэнэбулган, Төвшрүүлэх, Эрдэнэмандал, Хайрхан
- Дорнод аймаг: Хэрлэн, Халхгол, Хөлөнбуйр, Сэргэлэн
- Дундговь аймаг: Сайнцагаан, Дэлгэрцогт, Эрдэнэдалай, Сайхан-Овоо
- Хэнтий аймаг: Хэрлэн, Батширээт, Норовлин, Өмнөдэлгэр
- Сүхбаатар аймаг: Баруун-Урт, Түвшинширээ, Эрдэнэцагаан, Баяндэлгэр
- Өвөрхангай аймаг: Арвайхээр, Тарагт, Төгрөг, Хархорин

Төслийн хэрэгжилтэд орсон өөрчлөлт:

Санхүүжилтийн хэлэлцээрийн дагуу Нэмэлт санхүүжилт нь 2021 оны 9 сард дуусахаар байсан боловч дэлхий нийтийг хамарсан цар тахлын улмаас төслийн хэрэгжилтийн хугацааг сунгах хүсэлтийг Монгол улсын засгийн газраас тавьсаны дагуу ХААХОУС-аас төслийг 1 жилийн хугацаатай сунгаснаар төсөл нь 2022 оны 9 сар хүртэл хэрэгжихээр болсон.

Төсөл нь 6 аймгийн сонгогдсон 24 суманд хэрэгжихээр заасан боловч төслийн хэрэгжилтийн богино хугацаанд зээлийн хөрөнгийг үр ашигтай, бүрэн зарцуулах, үр дүнгийн тогтвортой байдлыг хангах үүднээс хөрөнгө оруулалтыг 6 аймгийн 98 суманд хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын үнийн дүнгийн 30 хувийг орон нутгаас гаргуулах зөвлөмж санхүүжүүлэгч байгууллагын 2019 оны 10 дугаар сард ажилласан Хяналт үнэлгээний ажлын хэсгээс өгсөн. Уг зөвлөмжийн дагуу хөрөнгө оруулалтыг 6 аймгийн бүх

суманд орон нутгийн хамтран санхүүжилттэй хэрэгжүүлэх ажлыг орон нутгийн болон үндэсний түвшинд хэлэлцэн зөвшилцөж 2020 оны жилийн ажлын төсөв төлөвлөгөөнд тусган баталгаажуулсан болно.